

Хотын Ардын депутатуудын гүйцэтгэх захиргааны дарга

1921 оны 7 дугаар сарын 6-анд Монгол ардын намын Төв хороо, Ардын түр засгийн газар нийслэл хүрээнд ирж, засгийн бүх эрхийг Ардын түр Засгийн газрын мэдэлд авч, Засгийн газрыг өргөтгөн байгуулж, Богдын засгийн газрыг татан буулгаснаас хойш, Нийслэл хотын түр захиргаа байгуулах хүртэл, Нийслэл хүрээний дотоод хэргийг Дотоод яамнаас эрхэлж байв.

1923-1924 онд Ардын төлөөлөгчдийн хурал шат дараалан байгуулагдаж, үүгээр төрийн эрх барих хурал хэмээх Ардын төлөөлөгчдийн байгууллагын шинэ систем тогтжээ.

1924 оны 8 дугаар сарын 11-энд Нийслэл хүрээнд “Хотын түр захиргаа” байгуулагджээ.

1924 оны 11 дугаар сарын 26-нд Улсын анхдугаар их хурлын 14 дугаар тогтоолоор нийслэл хотын нэрийг “Улаанбаатар хот” гэж нэрлэхээр тогтоосон юм.

БНМАУ-ын 2 дугаар их хурлын 9 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл, Засгийн газрын 22 дугаар тогтоолын 17 дугаар зүйлээр Засгийн газрын комиссын саналыг үндэслэн

1926 оны 9 дүгээр сарын 3-нд Ардын засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр

1927 оны 1 дүгээр сарын 1-нээ эхлэн хотын захиргааг Дотоод яамны харъяанаас өөрчилж, тусгай эрхтэй, биеэ даасан газар болгохоор тогтоожээ.

1931 оны 9 дугаар сарын 21-энд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлаар, Төв аймаг, Улаанбаатар хотын захиргаа, нутаг дэвсгэрийг нэгтгэн төвлөрүүлж, “Улаанбаатар” хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг мөн оны 10 дугаар сарын 1-нд хийхээр тогтоожээ.

1932 оны 8 дугаар сарын 22-нд Сайд нарын Зөвлөлийн 9 дугаар хурлын 3 дугаар зүйлээр Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг салгаж байгуулахаар шийдвэрлэсэн юм.

1937 оны 2 дугаар сарын 13-нд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн “Нийслэл Улаанбаатар хотыг захирах яам” болгохоор тогтоосон байна.

1939оны 3 сард улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор “хотыг захирах яам” хэмээн нэрлэхийг “Улаанбаатар хотын захиргаа” хэмээн нэрлэх болсон.

1940 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хуулиар “Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид” хэмээн тогтоосон.

1952 оны 11 дугаар сарын 1-нээс “Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа” хэмээн болжээ.

1962 оноос “Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа” хэмээн нэрлэж ирсэн.

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нар:

1. Моононгийн Баяр 1924-1926
2. Санжийн Батсүх 1926-11-27 1927-10-28
3. Дуламжавын Гомбожав 1927-10-28 1929-8-13
4. Лэгсрэнгийн Мижиддорж 1929-9-13 1929
5. Бадамын Цэрэндамба 1929 1930
6. Гомбожав 1930-1-31
7. Өлзийн Равдан 1932-7-4 1932
8. Дансрангийн Догсом 1932-8-27 1936-6-30
9. Дамдины Чимиддаваа 1933-6-30 1936
10. Гомбожав 1936-7-15 1939
11. Лодойн Тавхай 1939-5-9 1939
12. Сономын Лувсан 1939-11-16

13. Өлзийцогтын Мажиг 1941-1941-7 -24
14. Дамдин 1941-7-24
15. Рэндоогийн Лувсаннаваан 1941-9-19
16. Сономын Шагдар 1944-08-10
17. Гүндийн Багаа 1944-08-03 1956-5
18. Бадрахын Ламжав 1956-6 1956
19. Будын Батжаргал 1956 1959
20. Санжийн Батаа 1959 1962
21. Мангалжавын Лувсанчоймбол 1962 1965
22. Догсомын Цэдэв 1965-1971-1
23. Сономын Лувсангомбо 1971-3-10 1972-3 -21
24. Сүрэнжавын Балбар 1972-3-22 1976-5-27
25. Очирын Цэнд 1975-7-27 1978
26. Самбуугийн Мөнхжаргал 1978-Улаанбаатар хотын намын хорооны нэгдүгээр

нарийн бичгийн дарга нар:

1. Шийтэр 1925-4 1925-9
2. Галсаннамжилын Навааннамжил 1925-9 1925-11
3. Балжирхүндэв 1925-11 1928-8
4. Содномдоржийн Буяннэмэх 1928-8 1929-1
5. Чимэдийн Ранднаабазар 1929-1 1930-10
6. Бархасын Банзрагч 1930-10 1931-9
7. Дунгарын Чимэд 1931-9 1932-11
8. Шинданы Ринчин 1932-11 1934-4
9. Бадрахын Наваан 1934-4 1935-3
10. Ноостын Элээ 1935-3 1935-9
11. Дэлгэрнасангийн Бямбажав 1935 -9 1937-2
12. Лодойн Тавхай 1937-2 1937-10
13. Гүнжингийн Найдан 1937-10 1938-4
14. Цагааны Дариймаа 1938-4 1939-7
15. Дашийн Дамба 1939-7 1943-12
16. Бадамжавын Сосорбарам 1943-12 1945-12
17. Жүгдэрийн Чойдог 1945-12 1946-10
18. Арьяагийн Дагва 1946-10 1946-12
19. Банзрагчийн Дамдин 1947-1 1951-7
20. Цагаанламын Дүгэрсүрэн 1951-7 1952-8
21. Довчингийн Ламчин 1952-8 1954-8
22. Банзрагчийн Дамдин 1954-8 1985-4
23. Довчингийн Ламчин 1958-4 1949-4
24. Цагаанламын Дүгэрсүрэн 1959-4 1960-1
25. Намсрайн Лувсанравдан 1960-1 1963-4
26. Бат-очирын Алтангэрэл 1963-4

Эдгээр дарга нарын талаар: Засгийн газрын нууц.УТТА-ын фонд, Сайд нарын Зөвлөлийн 1926-1966 оны тогтоол, судалгаа Намын Төв хорооны боловсон хүчний хэлтсийн нам, Улсын удирдах ажилтны албан тушаалын карт,

Сайд нарын Зөвлөлийн захидал харилцааны хэлтсээс тусгай тэтгэвэрт холбогдуулж гаргасан судалгаа.

1924-10-28 Засгийн газрын эрхлэх товчооны 186 дугаар тогтоол

Улаанбаатар хотын захиргааны хэрэг эрхлэх газрын дарга Батсүхийн оронд Гомбожав, орлогч дарга Дамдинжавын оронд Дүгэржав нарыг сонгосныг ёсоор болгон баталжээ.

1929-08-13 Эрхлэх товчооны 24-р хурал 80 дугаар тогтоолын 4-р зүйл хотын захиргааны дарга Гомбожавыг чөлөөлж, мөн даргаар Ласрангийн Мижиддоржийг томилсныг Засгийн газрын 26-р хурлаар баталсан байна.

1937-02-05 Сайд нарын Зөвлөлийн 2-р хурал 2-р зүйл Улаанбаатар хотын захиргааг нийслэл Улаанбаатар хотыг захирах яам гэж нэрлэхэд даргаар Гомбожавыг хэвээр баталжээ.

1930-01-31 Засгийн газрын 5 дугаар тогтоолын 1-р зүйл Улаанбаатар хотын захиргааны 7 дугаар их хурлаас мөн захиргааны даргаар Гомбожавыг сонгосныг баталжээ.

1932-07-04 Сайд нарын Зөвлөлийн 1 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл Төв, Улаанбаатар аймгийн захиргааны даргаар Өлзийн Равданг томилжээ.

1932-08-27 Сайд нарын Зөвлөлийн 9-р тогтоолын 3-р зүйлээр Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг салгахад хотын захиргааны даргаар Дансрангийн Догсомыг томилжээ. Хамт байхад дарга нь Равдан байсан.

1933-01-06 Сайд нарын Зөвлөлийн 1-р тогтоолын 5-р зүйл Улаанбаатар хотын захиргааны их хурлаас хотын захиргааны даргаар Догсомыг сонгосныг баталжээ.

1933-06-30 Сайд нарын Зөвлөлийн 32-р хурлын 1-р зүйл Улаанбаатар хотын захиргааны орлогч даргын орон тоог 2 болгосон. Мөн хотын захиргааны даргаар Гомбожавыг томилжээ.

1933-06-30 Сайд нарын Зөвлөлийн 22 дугаар тогтоолын 3-р зүйл Улаанбаатар хотын захиргааны дарга Догсом өөр ажилд томилогдсон учир хотын захиргааны даргаар Дамдины Чимэд давааг томилжээ.

1936-07-161-р зүйл Улаанбаатар хотын захиргааны орлогч даргын орон тоог 2 болгосон. Мөн хотын захиргааны даргаар Гомбожавыг томилжээ.

1937-02-13 УБХ-ын тэргүүлэгчид, сайд нарын Зөвлөлийн 4/2-р хурлаар Улаанбаатар хотыг захирах яамны даргаар Дуламжавын Гомбожавыг томилжээ.

1939-05-09 Ардын сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайдын /улсын 22 дугаар бага хурлын 52 дугаар тушаал/хот захирах яамыг хотын захиргаа болгон өөрчилж Улаанбаатар хотын захиргааны даргаар Лодойн Тавхайг томилжээ.

1939-07-08 Ардын Сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайдын 74-р тушаал хотын захиргааны захирах тушаах хэргийг эрхлэх орлогч даргаар Дэчингомбыг томилжээ.

1941-02-19 Ерөнхий сайдын Хотын захиргааны дарга Мажиг байсан байна.

1941-07-24 Ерөнхий сайдын 84 дүгээр тушаал Улаанбаатар хотын захиргааны дарга Мажигийг өөр ажилд томилсон тул хотын захиргааны даргын үүргийг орлогч дарга Дамдинд 1941-4-27-ний дотор шилжүүлсэн.

1941-09-19 Сайд нарын Зөвлөлийн 48-р хурлын Улаанбаатар хотын захиргааны даргаар Хөвсгөл аймгийг дарга Рэндоогийн Лувсаннаваныг томилжээ.

1944-08-10 Сайд нарын Зөвлөлийн 82-р хурлын 5-р зүйл Улаанбаатар хотын захиргааны дарга Сономын Шагдар сургуульд суралцах учир чөлөөлж мөн даргаар Багааг томилжээ.

1946-42-6 Сайд нарын Зөвлөлийн 75-р хурал Улаанбаатар хотын захиргааны дарга Багаад өвчний учир удаан хугацааны чөлөө олгож мөн даргыг Чулуунбаатарт түр хавсруулан ажиллуулжээ.

1949 онд гаргасан боловсон хүчний бүртгэл, судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотын захиргааны даргаар -Мажиг

1940 онд-Лувсаннаван

1941 онд-Шагдар

1942-4943 онд-Гүндийн Багаа

1944-1978 онд тус тус ажиллажээ.

Аймаг хотын дарга нарын талаар 1949, 52, 88 онд Засгийн газраас гаргасан
бүртгэл судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотын даргаар-Мажиг

1940 онд-Наваанлуvsан

1941 онд -Сономын Шагдар

1942-1943 онд -Гүндийн Багаа

1944-8-3 1956-5-Бадрахын Ламжав

1956-5н.Очирын Цэндийг Улаанбаатар хотын АДХ*ын II дэх удаагийн
сонгуулийн IV чуулганаас Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргаар
сонгожээ.